

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
“ЧАДВАРЛАГ ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧ” УРАЛДААНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 04

Залаа

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулж буй “Чадварлаг эрх зүйн хөтөч” уралдаанд удирдамжийн дагуу төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж ажиллаа. Засаг даргын Тамгын газар нь 2024 онд сумын хэмжээнд Монгол Улсын хууль тогтоомжийг сурталчлан таниулах иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн ажлын үр дүнг сайжруулахаар зорилт тавин дараах ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар:

1.1.Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулахын тулд Сумын хэмжээнд болон Байгууллагын хэмжээнд сургалтыг 07 хоног бүр зохион байгуулсан. Сургалтыг сар бүр хуваарь гарган холбогдох албан хаагчидтай хамтран ажиллаж төлөвлөгөө боловсруулан ажилласан.

1.2.Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын тухай хуулийн талаар АХА тэмцээнийг Авто тээврийн үзлэгийн өдөр буюу 05 дугаар сарын 07-нд нийт 50 иргэдийн дунд зохион байгуулсан. АХА тэмцээний үеэр иргэдэд 200 ширхэг гарын авлага, иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг irgen.bayankhongor.gov.mn сайтаар нэвтэрч өгөх талаар QR кодтэй цаасан материалыг тарааж зааварчилгаа өгсөн. Хүүхэд багачуудын татварын тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Татвар хөгжлийн үндэс" сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж, нийт 16 хүүхэд бүтээл ирүүлснээс эхний 4 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан. Мөн 05 дугаар сарын 08-ны өдөр 9-р ангийн сурагчдад Эрх зүйн хөтөч цахим сайтын танилцуулга болон Татвар гэж юу вэ?, Ebarimt апплейкешнийг хэрхэн ашиглах талаар сургалт зөвлөгөөнийг зохион байгуулсан.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.1)

1.3.Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулахын тулд Байгууллагын хэмжээнд сургалтыг 07 хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулсан. Сургалтыг сар бүр хуваарь гарган холбогдох албан хаагчидтай хамтран ажиллаж, хууль тогтоомж сурталчлах ажлыг хамтран зохион байгууллаа. Мөн Долоо хоног бүрийн Даваа гарагт Иргэдийн мэдээллийн цагийн хуваарийг гаргаж бүх

албан хаагчид, албан байгууллагууд хамтран ажиллаж иргэдэд холбогдох сургалт, зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллалаа.

1.4.Тайланг, биелэлтийн хамт хугацаанд нь хүргүүлсэн.

1.5.Архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг баримтлан тайланг хүргүүлсэн.

1.6.Долоо хоног бүрийн “мэдээллийн цаг”, “байгууллагын сургалтын цаг”-уудад албан хаагчид, иргэдийн хамруулахад анхаарал хандуулж, аливаа зохион байгуулах ажилд шаардалагатай мөнгө санхүүгийн ажлыг шийдэж ажилласан.

Хоёр.Цахим систем ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр:

2.1.Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнуудад 04 сарын 12-ны өдөр “Эрх зүйн хөтөч цахим сайтын танилцуулгын сургалт орсон. Сургалтад нийт 29 албан хаагч хамрагдсан. 04 сарын 15-ны өдрийн Иргэдийн мэдээллийн цагаар “Эрх зүйн хөтөч цахим сайтын танилцуулга”-ыг 22 иргэн, 68 төрийн албан хаагчдад орсон. Сургалтад хамрагдсан иргэдэд утсаар нь цахим сайтад руу нэвтрүүлж, бүртгэл үүсгэж цаашид өөрсдөө үйлчилгээг хэрхэн авах талаар зааварчилгааг өгсөн.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.2.1)

2.2.Авлигатай тэмцэх газрын сайтад нэвтэрч, Шинэжинст ЗДТГ, shinejinst shinejinst фэйсбүүк хаягуудаар холбогдох нийтлэл, зурагт хуудсуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.2.2)

2.3.Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Үндсэн хуулийн талаар нийт 200 ширхэг гарын авлага хийж, иргэдэд тарааж, байгууллагын дарга нарын групп рүү файлуудыг өгсөн. *(Холбогдох зураг хавсралтаар Зураг.2.3)*

Гурав.Иргэд, төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлын чиглэлээр:

3.1.Хууль тогтоомж сурталчилсан богино хэмжээний шторкийг III улиралд хийхээр төлөвлөж байна.

3.2.Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Үндсэн хуулийн талаар нийт 200 ширхэг гарын авлага хийж, байгууллагын дарга нартай биечлэн уулзаж, хууль эрх зүйн чиглэлээр 2024 онд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг танилцуулж, хамтран ажиллах талаар уулзалт хийж 10 ширхэг гарын авлагыг тус тус тарааж өгсөн. 100 ширхэг гарын авлагыг Тээврийн үзлэгийн үеэр иргэдэд тарааж ажилласан. Мөн угтах үйлчилгээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний

өдрөөс эхлэн 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж ажилласан. Энэ үеэр угтах үйлчилгээний жижүүрүүдэд холбогдох албан тушаалтнууд гарын авлага, ном сонин, зөвлөмжүүдийг хэвлэн өгч иргэдэд таараалгаж ажилласан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.1)

3.3.Угтах үйлчилгээний жижүүрүүдэд холбогдох албан тушаалтнууд гарын авлага, ном сонин, зөвлөмжүүдийг хэвлэн өгч иргэдэд таараалгаж, байгууллагын мэдээллийн самбарын мэдээ шинэчлэлд тухайн өдрийн жижүүрүүд хяналт тавьж ажилласан. Мөн мэдээллийн самбарын мэдээлэл шинэчлэлд төрийн үйлчилгээний оператор давхар хяналт тавьж, хоцрогдсон мэдээ мэдээллийг солиулж ажиллаж байна.

3.4.2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр томилогдсон Төрийн үйлчилгээний ажилтан, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс томилогдсон Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ш.Даваацэрэн нарыг 2024 оны 02 дугаар 21-ний өдрийн "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь" сэдэвтэй сургалтад хамруулсан.

3.5.Хүүхэд багачуудын татварын тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Татвар хөгжлийн үндэс" сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж, нийт 16 хүүхэд бүтээл ирүүлснээс эхний 4 байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.1.1)

3.6.Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө тусламж өгөх зорилгоор Долоо хоног бүрийн Даваа гарагт иргэдийн "мэдээллийн цаг"-ийг 2024 оны 05 дугаар сарын 13-ний өдрийг хүртэл зохион байгуулсан. Мэдээллийн цагаар бүх албан байгууллагын захирал, дарга, эрхлэгч болон төрийн албан хаагчид өөрсдийн ажил мэргэжлийн онцлогоос хамаарч шинэчлэгдсэн болон иргэдэд хэрэгтэй хууль тогтоомж, зөвлөгөө мэдээллийг нийт 11 удаагийн сургалтаар зохион байгуулсан. Үүнд:

- Төрийн жинхэнэ албан хаагчийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал /Төрийн албан хаагчид/
- Ёс зүйн тухай ~~шинэ~~ хууль /Байгууллага/
- "Хүүхдийн эрх" /Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын багтай хамтран 4-р сургуулийн сэтгэл зүйч П.Сэнгэмаа /
- "Хүүхэд хамгааллын бодлого" /Мэдээллийн цаг/
- Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан зохион байгуулсан нээлттэй өдөрлөг зохиогдсон. Өдөрлөгөөр илтгэлийн уралдаан, чуулган, спортын тэмцээн, нэг цэгийн үйлчилгээ зэрэг олон үйл ажиллагааг зохион

Бүтэц
алба
хаагчид

байгуулсан. Нэг цэгийн үйлчилгээгээр Тамгын газрын албан хаагчид албан тушаалын онцлог бүрийн эрх зүйн зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.

- Цэцэрлэгээс өөрсдийн мэргэжлийн талаарх сургалт
- "Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт" /Байгууллага/
- ТАХА ➤ Ёс зүйн тухай шинэ хууль болон байгууллагын соёл /Байгууллага/
- Архив албан хэрэг хөтлөлтийн стандарт /Байгууллага/
- Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох журам /Мэдээллийн цаг/
- Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Мэндбаяр "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийн нээлтийн үйл ажиллагааг хийж, Хүүхэд хамгааллын шинэчилсэн хуулийг олон нийтэд сурталчлах сургалт орж, мөн Аймгийн Өсвөр үе охидын эмч Т.Одонтунгалаг 8-9-р ангийн сурагчдад өсвөр үеийн эрүүл мэндийн сургалт зохион байгуулж ажиллалаа.
- Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга /Мэдээллийн цаг/
- Эрх зүйн хөтөч цахим сайтын танилцуулга /Мэдээллийн цаг/
- Эрүүл мэндийн төвийн байгууллагаас Сувилагчийн өдөрт зориулж нээлттэй өдөрлөг зохион байгуулж, ард иргэдэд анхан шатны зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллалаа.
- ХАБЭА-н сургалт /Байгууллага/
- Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, хүмүүнлэгийн сэтгэл судлаач, доктор, Лектор Чила буюу Г.Бандицэрэн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр ЕБС-ийн сурагчдад "Сурч боловсрохын ач холбогдол, үе тэнгийн дээрэлхэлт", Төрийн албан хаагч, иргэд, эцэг эхчүүдэд "Хүний хөгжил, амьдралын үнэ цэнэ, гэр бүлийн сэтгэл зүй" сэдвээр сургалт орж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилсан. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.3.1)

Мөн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр аймгийн Хууль, эрх зүйн хэлтэсийн ажлын хэсэгтэй хамтран иргэд, төрийн албан хаагчид нийт 98 хүнийг хамруулан

- Хүний эрхийн тухай ойлголт
- Хүний эрх хамгаалагчийн тухай хууль
- Хүүхдийн эрх
- Хүнсний аюулгүй байдал
- Хэрэглэгчийн тухай хууль
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь
- Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, хүүхдийн эрх үүрэг

огцлоор
Зэрэг хуулиар сургалт орж хуулийн мэдлэг мэдээллийг өгч ажиллалаа.
(Холбогдох зураг хавсралтаар Зураг. 3.4)

3.7. <https://d.parliament.mn/> сайтын талаар иргэд болон албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.

3.8. Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын тухай хууль холбогдуулан АХА тэмцээнийг Авто тээврийн үзлэгийн өдөр нийт 50 иргэдийн дунд зохион байгуулсан. АХА тэмцээний үеэр иргэдэд 200 ширхэг гарын авлага, иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг irgen.bayankhongor.gov.mn сайтаар нэвтэрч өгөх талаар QR кодтэй цаасан материалыг тарааж зааварчилгаа өгсөн. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.1.1.1)

3.9. <https://shinejinst.bkh.gov.mn/> цахим сайтад Төрийн үйлчилгээний оператортай хамтран 98 нэр төрлийн мэдээллийг байршуулсан.

3.11. “Төрийн мэдээлэл” 2023 оны сэтгүүлийн архивласан байна.

2024 оны “төрийн мэдээлэл” сэтгүүлийг захиалан өөрчлөлт хөдөлгөөнийг хийж ажиллаж байна.

3.12. Хууль тогтоомжийн хүрээнд иргэдэд өөрсдийн албан тушаалын онцлогоос хамаарч зөвлөгөө мэдээлэл, хүргэж ажилласан бол бүртгэх бүртгэлийн маягтыг байгууллагын дарга, эрхлэгч, захирал болон албан хаагчдад файлаар өгч ажилласан.

Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн – 15

Нийгмийн бодлогын мэргэжилтэн – 11

Нийгмийн даатгалын улсын байцаагч – 21

Байгаль орчны хяналтын улсын байцаагч-3

Татварын улсын байцаагч – 12


Хууль эрх зүйн мэргэжилтэн – 10 тус тус үйлчилгээг үзүүлсэн. Нийт зөвлөгөө өгсөн иргэн -175

(Холбогдох зураг хавсралтаар Зураг.3.2)

3.13. Аймгийн прокурорын газраас 2024 оны 4 дугаар сарын 30-ны өдрийн 1/11 тоотор Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан “Байгаль орчин, амьтан ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил”-үүдэд анхаарч ажиллаж, гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай мэдэгдэл ирсэн. Энэхүү мэдэгдлийн дагуу “Зөрчлийн тухай хууль” “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” болон бусад хууль тогтоомжоор гарын авлага бэлтгэн Шинэжинст сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал гэсэн цахим хаягт

байршуулсан. Мөн цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням Эрүүгийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар иргэдэд сургалт орсон. Мөн сумын ИТХ-аар байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөлийн баримтлах зарчмын дагуу "Баян сайр" нөхөрлөлийг байгуулсан. Эрдэнэшанд 3 дугаар багийн "Баян сайр" нөхөрлөлд ан амьтан хамгаалах чиглэлээр багаас Цагаан булгийн гашуун, Жадын хүрэн бууц, Өвчүү хүртэлх энгийн хамгаалалтын бүсийн дагуух газрыг хариуцуулахаар болж албан ёсны нөхөрлөл байгуулагдсан. Нөхөрлөлийн даргаар тус багийн малчин Д.Алтансүх ажиллаж байна. Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөл энэ нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллаж байна. (Холбогдох зураг хавсралтаар Зураг.3.3)

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА  Д.БАТХУЯГ

ТАЙЛАН БИЧСЭН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Ц.НАРАНЦЭЦЭГ

Хавсралт

Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын тухай хуулийн талаар АХА тэмцээнийг зохион байгуулж, гарын авлага тараалаа.



Зураг.1.1

"Татвар хөгжлийн үндэс" сэдэвт гар зургийн уралдаан




Зураг.1.1.1

9-р ангийн сурагчдад Эрх зүйн хөтөч цахим сайтын танилцуулга болон Татвар гэж юу вэ?, Ebarimt апплейкешнийг хэрхэн ашиглах талаар сургалт зохион байгууллаа.



Зураг.1.1.2

Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнуудад 04 сарын 12-ны өдөр “Эрх зүйн хөтөч цахим сайтны танилцуулгын сургалт орлоо.



Зураг.2.1





Зураг.2.2



Авлигатай тэмцэх газрын сайтад нэвтэрч, Шинэжинст ЗДТГ, shinejinst shinejinst фэйсбүүк хаягуудаар холбогдох нийтлэл, зурагт хуудсуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Зураг.3.1. Иргэдийн мэдээллийн цаг





Хууль тогтоомжийн хүрээнд иргэдэд өөрсдийн албан тушаалын онцлогын хүрээнд зөвлөгөө мэдээлэл, хүргэж ажилласан бол бүртгэх бүртгэлийн маягтыг байгууллагын дарга, эрхлэгч, захирал болон албан хаагчдад файлаар өгч ажилласан.



Зураг.3.2

Цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням Эрүүгийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар иргэдэд сургалт орсон.



Зураг.3.3

Хүний эрхийн тухай ойлголт, Хүний эрх хамгалагчийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай, Хэрэглэгчийн эрх, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг зэрэг хуулиар Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран сургалт орлоо.



СУРГАЛТАД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ИРЭДНИЙ БҮЛЭГ

Бүтцийн хэрэгсэл боловсролтой дүншилтэй арга хэмжээний үр дүн

Сургалтын мөнгөтэй...

Сургалтын үр дүн

1. Хүний эрхийн тухай ойлголт, Хүний эрх хамгалагчийн тухай хууль

2. Хүүхдийн эрх

3. Хүнсний аюулгүй байдал

4. Хэрэглэгчийн эрх

5. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь

6. Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг

2024 оны 09 дугаар сарын

№	Огноо	Нэгдсэн			Хүснэгт	Хүснэгт	Тогтвортой өөрчлөлт		Мөнгө	Тогтвортой өөрчлөлт	Тогтвортой өөрчлөлт	Тогтвортой өөрчлөлт
		21-30	31-40	41-50			Хүснэгт	Хүснэгт				
1	Хүний эрхийн тухай ойлголт											
2	Хүүхдийн эрх											
3	Хүнсний аюулгүй байдал											
4	Хэрэглэгчийн эрх											
5	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь											
6	Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг											
7	Хүний эрхийн тухай ойлголт											
8	Хүүхдийн эрх											
9	Хүнсний аюулгүй байдал											
10	Хэрэглэгчийн эрх											
11	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь											
12	Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг											
13	Хүний эрхийн тухай ойлголт											
14	Хүүхдийн эрх											
15	Хүнсний аюулгүй байдал											
16	Хэрэглэгчийн эрх											
17	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь											
18	Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг											

1	Хүний эрхийн тухай ойлголт											
2	Хүүхдийн эрх											
3	Хүнсний аюулгүй байдал											
4	Хэрэглэгчийн эрх											
5	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь											
6	Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг											
7	Хүний эрхийн тухай ойлголт											
8	Хүүхдийн эрх											
9	Хүнсний аюулгүй байдал											
10	Хэрэглэгчийн эрх											
11	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь											
12	Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг											
13	Хүний эрхийн тухай ойлголт											
14	Хүүхдийн эрх											
15	Хүнсний аюулгүй байдал											
16	Хэрэглэгчийн эрх											
17	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь											
18	Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг											

Зураг 3.4